



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/05-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2022 он

ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК

Утас: 77270808 Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
4. Аудитын тайлан.....	10
4.1 Ерөнхий зүйл.....	10
4.2 Дотоод хяналт.....	10
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
4.4 Материаллаг байдал.....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
8. Аудитын илрүүлэлт.....	13
8.1 Залруулсан алдаа.....	13
8.2 Зөвлөмж.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

ААНБОАТ	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын их хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

“ХҮДЭР ОЙН АНГИ” ОНӨААТҮГ-
ЫН ДАРГА Г.ТАЙВАНБААТАР
ТАНАА

2022.03.15 № СЭА 2022/05-НА СТА-ОНА
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. *Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.*

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

СЭА-2022/05-НА-СТА-ОНА

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,133,633.18	73,215,802.96
1.1.6	Бараа материал	-	1,836,300.00
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	4,133,633.18	75,052,102.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,543,664.84	20,509,197.80
1.2.2	Биет бус хөрөнгө	1,500,000.00	1,500,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,043,664.84	22,009,197.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,177,298.02	97,061,300.76
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1.3	Татварын өр	-	768,800.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	768,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	768,800.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	төрийн	23,900,942.97	23,900,942.97
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(3,723,644.95)	72,391,557.79
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг		76,115,202.74
2.3.10	Өмнөх үеийн ашиг	(2,956,385.07)	(3,723,644.95)
2.3.11			
2.3.12.	Эздийн өмчийн дүн	20,177,298.02	96,292,500.76
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,177,298.02	97,061,300.76

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	46,188,575.00	161,469,850.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	46,188,575.00	161,469,850.00
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	46,955,834.88	85,354,647.26
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	
17	Бусад ашиг (алдагдал)	-	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(767,259.88)	76,115,202.74
19	Орлогын татварын зардал	-	768,800.0
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(767,259.88)	75,346,402.74
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(767,259.88)	75,346,402.74
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	
23.3	Бусад олз (гарз)	-	
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(767,259.88)	75,346,402.74
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,900,942.97	(3,723,644.95)	23,900,942.97
2	Залруулсан үлдэгдэл	23,900,942.97	(3,723,644.95)	23,900,942.97
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		76,115,202.74	
	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,900,942.97	72,391,557.79	96,292,500.76
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			
5	Залруулсан үлдэгдэл	23,900,942.97	72,391,557.79	96,292,500.76
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			
6	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0.00	72,391,557.79	96,292,500.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	46,170,700.00	161,469,850.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	46,170,700.00	161,469,850.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	41,692,007.96	82,227,680.22
1.2.1	Ажиллагчдад төлсөн	29,218,293.96	39,909,137.00

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,111,774.00	4,802,625.99
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	395,200.00	11,808,000.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн		-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,500,000.00	3,054,437.87
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,895,840.00	784,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	570,900.00	21,869,479.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,478,692.04	79,242,169.78
2.2	Мөнгөн зарлагын дүн	1,500,000.00	10,160,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		10,160,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,500,000.00	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,978,692.04	69,082,169.78
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,154,941.14	4,133,633.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,133,633.18	73,215,802.96

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих хэгж	2020 оны гүйцэтгэл	2021 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Талбай тусгаарлалт орлого	мян.төг	46188.5	41,045.4	66,443.0	(25,397.6)	161.9
2	Ойжуулалт нөхөн сэргээлт орлого	мян.төг		23,810.0	35,842.4	(12,032.4)	150.5
3	Бусад эх үүсвэр орлого	мян.төг			57,128.0	(57,128.0)	0
4	Үнэт цаасны орлого	мян.төг		340.0	2,056.4	(1,716.4)	604.8
5	Нийт орлогын дүн	мян.төг	46,188.5	65,195.4	161,469.8	(96,274.4)	247.7
6	Үүнээс: Цэвэр Борлуулалт	мян.төг				-	
7	Нийт зардал	мян.төг	46,170.7	65,195.4	85,354.6	(20,159.2)	130.9
8	ББӨ	мян.төг				-	
9	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	41,692.0	65,195.4	85,354.6	(20,159.2)	130.9
11	Нийт ашиг алдагдал	мян.төг	(767.2)	-	76,115.2	(76,115.2)	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах,
- Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох,
- Аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох,
- Ойн санд байршин амьдардаг зэрлэг ан амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх ажлыг хариуцах, улсын ойн санд таримал ойг хүлээн авах,

Тус аж ахуйн нэгжийг Хүдэр сумын ИТХ-аас “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд 100 хувь орон нутгийн өмчид харьяалагдаж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Хүдэр ойн анги” ОНӨААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 107 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “ТБОНӨБАҮ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” гэх мэт.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,133.6	73,215.8	69,082.2
Бараа материал		1,836.3	1,836.3
Үндсэн хөрөнгө	16,043.7	22,009.2	5,965.5
Нийт хөрөнгө	20,177.3	97,061.3	76,884.0
Богино хугацаат өр төлбөр		768.8	768.8
Эздийн өмч /Төрийн өмч/	20,177.3	97,061.3	76,884.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,177.3	97,061.3	76,884.0

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 73,215.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,082.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 1,836.3 мянган төгрөгийн мод, хангамжийн материал тайлагнагдсан нь тайлант онд 17,480.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 15,644.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 10,160.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 6,000.0 мянган төгрөгөөр дрон, 3,500.0 мянган төгрөгөөр компьютер, 460.0 мянган төгрөгөөр хэвлэгч худалдан авснаас шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр 768.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан татварын өглөг байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 97,061.3 мянган төгрөг болж 76,884.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашигтай холбоотой байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор “Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны үйл ажиллагааны орлого, зардлыг 44,150.0 мянган төгрөгөөр баталсныг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор 65,195.4 мянган төгрөгөөр буюу 21,045.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн өөрчилсөн байна.

Тайлант онд 65,195.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **161,469.8** мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 147.7 хувиар буюу 96,274.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь самрын талбай тусгаарлалтын орлогыг нэмж төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Нийт зарлагыг 65,195.4 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр **85,354.6** мянган төгрөг буюу 20,159.2 мянган төгрөгөөр хэтэрсэн нь бусад зардлыг хэтрүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд **76,115.2** мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын “Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын /цаашид “Хүдэр Ойн анги” гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллагын дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлага, өглөгийн данс, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитын менежер Ц.Энхтуяа гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайланг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд үйлдвэрийн газрын өөрийн дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн 97,061.3 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 1,942.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т: “хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх” зохицуулалттай байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллээс 44 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 102 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээлэл байршуулаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д *“Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”* гэж заасны дагуу шагнал урамшуулал олгоогүй, зочин төлөөлөгч хүлээн авах болон бэлэг дурсгалын зардал гаргаагүй байна.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлснээс 1 албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	1	-	1		50.0
Зөвлөмж	1		1				100.0
Нийт дүн	3		2		1		66.6

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн мэдээлээгүй зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35,240.0 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 6,360.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 28,880.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт тооцоолол болон тайлагналын алдаатай 6,360.0 мянган төгрөгийн дараах алдааг аудитын явцад залруулсан болно. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь борлуулалтын орлогыг ААНОАТ-ын тайлангийн дүнгээс 1,250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын тайлангийн нийт цалинг орлого үр дүнгийн цалингийн зардлаас 1,203.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Мөнгөн гүйлгээний тайлан дахь цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн дүнг ерөнхий журналын дүнгээс 3,906.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын өр төлбөртэй холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт**: Тайлант онд 768.8 мянган төгрөгийн татварын өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “... тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. **Өгсөн зөвлөмж**:

Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, цаашид холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

2. Цалин хөлстэй холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт**: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн цалингийн дүнг санхүүгийн тайлангийн цалингийн дүнгээс 203.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь НДШ-ийн акт, өр төлбөр тавигдах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.1.1 “Ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох

шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** 2022 оны 1 дүгээр улирлын тайланд залруулга хийх, холбогдох хууль, тогтоомж, заавар, журмыг мөрдөж ажиллах.

3. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

3.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 27,907.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

3.2 **Өгсөн зөвлөмж:** Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА-2022/05/-НА-СТА-ОНА	Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь борлуулалтын орлого ААНОАТ-ын тайлангийн дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн.	Залруулсан	1	1,250.0	1	1,250.0								
2	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА-2022/05/-НА-СТА-ОНА	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын нийт цалин орлого үр дүнгийн дүнг зөрүүтэй илэрхийлсэн	Залруулсан	1	1,203.2	1	1,203.2								
3	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА-2022/05/-НА-СТА-ОНА	Мөнгөн гүйлгээний тайлан дахь цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн дүн ерөнхий журналаас зөрүүтэй илэрхийлсэн	Залруулсан	1	3,906.8	1	3,906.8								
4	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА-2022/05/-НА-СТА-ОНА	Тайлант хугацаанд өглөг үүсгэсэн, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	Зөвлөмж	1	768,8								1	768.8	
5	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА-2022/05/-НА-СТА-ОНА	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн цалингийн дүн санхүүгийн тайлангийн цалингийн дүнгээс 203.6 мянган төгрөгөөр илэрхийлсэн	Зөвлөмж	1	203.6								1	203.6	
6	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА-2022/05/-НА-СТА-ОНА	Тайлант онд 27,907.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй	Зөвлөмж	1	27,907.6								1	27,907.6	
ДҮН					6	35,240.0	3	6,360.0						3	28,880.0	
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																

“Хүдэр Ойн анги” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	Хүдэр Ойн анги ОНӨААТҮГ	СЭА- 2022/05/- НА-СТА- ОНА	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 44 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 102 мэдээллийг хугацаа хоцроож 5 мэдээллийг огт мэдээлээгүй байна.	Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн	1	-							1			
ДҮН					1	-							1			
НИЙТ ДҮН					7	35,240.00	3	6,360.0					1	3	28,880.0	